

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2020 оны эхний хагас жил (2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийг дуустал)-д дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн хувийн урилга, виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 4591 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгосноос 3920 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт, 671 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад тус тус илгээлээ.

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 2018 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын Монгол Улсын визийг олгож, 12 иргэнд визийн шилжүүлэг хийсэн. *(График 1)*

2021 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл 2 дахин, оршин суух зөвшөөрөл олголт 33.5 хувь, оршин суух зөвшөөрөл сунгалт 42.0 хувиар өсөж, виз олголт 64.8 хувь, оршин суух зөвшөөрөл хасалт 73.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 2062 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 10133 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 2264 иргэний бүртгэлд хасалт хийсэн. *(График 1)*


Мөн оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 135 гадаадын иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлж, уригч 115 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 176 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон байна.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 781 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 696 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 275 иргэний визийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, гадаадын 17 иргэнд регистрийн дугаар олгосон. *(График 1)*

Энэ оны хагас жилийн тоон үзүүлэлтийг 2020 оны хагас жилийн тоон үзүүлэлттэй харьцуулахад түр ирэгчийн бүртгэл 63.6 хувь, түр ирэгчийн хасалт 75.3 хувь, визийн хугацааны сунгалт 81.9 хувиар мөн буурчээ.

Монгол Улсад оршин суух цахим үнэмлэхийг 3532 ширхэг шинээр хэвлэн, 8602 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 624 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

График 1



Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 11641 иргэн (1800-1882 дугаарын утсаар 8157, биечлэн 266, автомат хариулагчаар 1912, имэйлээр 94, фэйсбоок хуудасны чатботоор 1212)-д зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба код мессеж үйлчилгээг 727 иргэнд илгээсэн.

Тайлант хугацаанд нийт 493 аж ахуйн нэгж, байгууллагын 849 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eVisa.mn)-аар хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Т” ангиллын 196 аж ахуйн нэгж, байгууллагын 262 гадаадын иргэн,
- “НГ” ангиллын 227 аж ахуйн нэгж, байгууллагын 427 гадаадын иргэн,
- “S” ангиллын 5 аж ахуйн нэгж, байгууллагын 10 гадаадын иргэн,
- хувийн хэргээр оршин суугч 30 гадаадын иргэн,
- түр ирэгчээр визийн байх хугацааг сунгуулах 21 гадаадын иргэний хүсэлт,
- визийн зөвшөөрөл хүссэн 55 аж ахуйн нэгж, байгууллагын 88 гадаадын иргэний хүсэлт (“А” ангиллын 9, “В” ангиллын 29, “О” ангиллын 3, “Т” ангиллын 47 гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн орох)-ийг тус тус хянан шийдвэрлэж, 10 аж ахуйн нэгж, байгууллагын 11 гадаадын иргэний хүсэлтэд татгалзсан байна.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Монгол Улсын харьяат болох, гарах, сэргээн тогтоолгох:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 140 дүгээр, 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 152 дугаар, 06 дугаар сарын 10-ны өдрийн 162, 163 дугаар зарлигаар гадаад улсын 4 иргэн (*Казакстан Улсын 1, Хятад Улсын 2, Орос Улсын 1*) Монгол Улсын харьяат болсон.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 18 иргэн (*Хятад Улсын 16, Энэтхэг Улсын 1, харьяалалгүй 1 хүн*)-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т заасан шаардлагыг хангаагүй гадаадын 3 иргэн (*Хятад Улсын 1, Энэтхэг Улсын 1, харьяалалгүй 1 хүн*)-ний харьяат болох хүсэлтийг түдгэлзүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 20 иргэний хүсэлт, баримт бичигт санал авахаар Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газарт, гадаадын 19 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналд дүгнэлт үйлдэн, Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, гадаадын 20 иргэний хүсэлтийг Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 12 удаагийн зарлигаар 165 иргэн бусад улсын харьяат болох (*Австри Улсын 14, Өмнөд Солонгос Улсын 47, Нидерланд Улсын 1, Сингапур Улсын 5, Хятад Улсын /Тайвань/ 1, Казакстан Улсын 21, Герман Улсын 60, Япон Улсын харьяат болох 16*)-оор Монгол Улсын харьяатаас гарсан.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 85 иргэн (*Америк Улсын 1, Австри Улсын 11, Казакстан Улсын 4, Өмнөд Солонгос Улсын 30, Нидерланд Улсын 1, Герман Улсын 28, Япон Улсын харьяат болох 10*)-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 86 иргэний хүсэлт, баримт бичигт санал авахаар Улсын Бүртгэлийн Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газарт, 74 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналд дүгнэлт үйлдэн, Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 90 иргэний хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 96, 97 дугаар зарлигаар харьяалалгүй 19 хүн (*Өмнөд Солонгос Улсын 2, Казакстан Улсын харьяатаас гарсан 17*) тус улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 10 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, хүсэлт гаргасан 7 харьяалалгүй хүний хүсэлтэд санал авахаар Улсын Бүртгэлийн Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газарт, 7 иргэний хүсэлтийг хянан, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналд дүгнэлт үйлдэн, Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 6 харьяалалгүй хүний хүсэлтэд дүгнэлт үйлдэн, Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Дээрх хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 48 иргэнийг шинээр бүртгэж, бүртгэлийг мэдээллийн санд оруулсан. (*График 2*)

06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор гадаадын иргэний нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3848 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

График 2



1.2.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх 1, зөвшөөрлийн хугацааг сунгуулах 27 нийт 28 байгууллагын хүсэлтийг хүлээн авч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн 2, зөвшөөрлийн хугацааг хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 38 нийт 40 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтэд санал авахаар баримт бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

“Мэргэжлийн зөвлөл”-ийн 2 удаагийн хурлаар хүсэлт гаргасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн 19 (*шинээр нээх 2 /давхардсан тоогоор/, сунгуулах 17*) газрын хүсэлтийг хэлэлцүүлж шийдвэрлэжээ.

2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 87 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.

1.2.3. Хүүхэд үрчлэлт:

2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Мэргэжлийн зөвлөлийн хурал”-аар Монгол Улсын харьяат 1 хүүхдийг Америкийн Нэгдсэн Улсын иргэн Захари Мартин Пиле, Витней Эвэтти Пиле нарт үрчлүүлэх шийдвэр гарч, 03 дугаар сарын 16-ны өдөр үрчлэлтийн дараа хяналт тавих 2 талт гэрээг байгууллаа.

Гадаад улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн (*Америк Улсад 6, Итали Улсад 3, Англи Улсад 1, Герман Улсад 16*) Монгол Улсын харьяат нийт 26 хүүхдийн тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн, 2020 онд үрчлэлтийн дараах тайлан ирүүлээгүй 59 хүүхдийн жагсаалтыг Гадаад харилцааны яамны Консулын газарт хүргүүлсэн.

06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд 273 хүүхдийг үрчлүүлсэн байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Тайлант хугацаанд 13 удаагийн төлөвлөгөөт, 49 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 125 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 539 иргэнийг хамруулснаас гадаадын 47 иргэн, 6 уригч байгууллага (10 иргэн)-д Зөрчлийн тухай хуулийн дагуу 15.190.000 төгрөг (Арван таван сая нэг зуун ерэн мянган)-ийн шийтгэл оногдуулж, улсын төсөвт төвлөрүүлээ.


1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийг үндэслэн 10 улсын 18 иргэн (Австрали Улсын 1, Казакстан Улсын 1, Өмнөд Солонгос Улсын 1, Хятад Улсын 7, Англи Улсын 1, Нидерланд Улсын 1, Орос Улсын 3, Украин Улсын 1, Румын Улсын 1, Тайланд Улсын 1)-ийг албадан гаргасан. (График 3)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 5 улсын 16 иргэн (Казакстан Улсын 1, Өмнөд Солонгос Улсын 4, Хятад Улсын 8, Орос Улсын 2, Герман Улсын 1)-ийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүллээ. (График 3)

Энэ оны эхний хагас жилд Монгол Улсаас албадан гаргагдсан гадаадын иргэний тоон үзүүлэлт 2020 оны хагас жилийн үзүүлэлтээс 56.8 хувь, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний үзүүлэлт 56.8 хувиар буурчээ.

График 3



2021 оны эхний хагас жилийн тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 87.2 хувь, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 98.9 хувиар тус тус буурч, зөрчил гаргасан уригч иргэн бүртгэгдээгүй байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн

чиглэлийн тус байгууллагад холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/1872 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланд байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, мөн өдөр цахимаар болон 01/862 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээ.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Гадаадын иргэн, харьяатын газрын удирдлага, албан хаагчдад өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлэв.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/534 дүгээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу 2021 оны нэгдүгээр улирлын танилцуулах мэдээг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/445 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын 2021 оны нэгдүгээр улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/519 дүгээр албан бичгээр, 2021 оны 01 дүгээр сарын 12, 02 дугаар сарын 25, 04 дүгээр сарын 27-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг тухай бүр холбогдох хугацаанд нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудал, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, “Аж ахуйн нэгжийн тооллого”-ын үзэл баримтлал, асуулга, Хилийн боомтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд тус тус саналыг нэгтгэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд мөн хүргүүлсэн.

Улсын Их Хурлын чуулган дээр Монгол Улсын Ерөнхий сайдын хэлсэн үгэнд тусгагдсан нэн тэргүүнд хэрэгжилтийг хангах шаардлагатай, Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн ажлын тайланд тусгах тус байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01/613, 01/614 дүгээр, Монгол Улсын Засгийн газраас 100 хоногийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын 2021 оны төлөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тусгасан арга хэмжээний биелэлтийг мөн сарын 28-ны өдрийн 01/617 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яаманд хүргүүлж тайлагналаа.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг

батлах тухай” А/20 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан байгууллагын даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар албан хаагчдыг ажлаас чөлөөлж, мөн өдрийн Б/48 дугаар тушаалаар зохион байгуулалтын нэгжийн ажил, албан тушаалын жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага туршлага, тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг харгалзан шинээр томиллоо.

Бүтцийн өөрчлөлтийг ажлын байрны зураг авалтын нэгдсэн дүн, ажлын байрны шинжилгээний санал дүгнэлтийг тус тус харгалзан, байгууллагын орон тоог нэмэгдүүлэлгүйгээр албан хаагчдын эрх зүйн байдлыг хөндөхгүй байхад анхаарч, нийт албан хаагчдын 78.1 хувьд эрх зүйн байдал хэвээр, 20.3 хувьд эрх зүйн байдал дээшилсэн, 1.6 хувьд эрх зүйн байдал хөндөгдсөн үзүүлэлттэй байна.

Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд албан тушаалын ангилал, зэрэглэл ахисан, дэвшүүлэн томилсон, хяналтын улсын байцаагчийн эрх шинээр болон сэргээн олгосон, албан хаагчийн хүсэлтийг харгалзан шилжүүлэн томилсон нийт 63 албан хаагчаас 19 буюу 31.1 хувийг албан тушаал дэвшүүлж, 13 буюу 21.3 хувийн ангилал, зэрэглэлийг тус тус ахиулсан бол 6 буюу 14.2 хувьд хяналтын улсын байцаагчийн эрхийг шинээр болон сэргээн олгож, эрх зүйн байдлыг дээшлүүлжээ.

Эхний хагас жилийн байдлаар тус байгууллагад шинээр 39, нэгж хооронд шилжин 22, дэвшүүлэн 19, бууруулан 7, хүүхэд асрах чөлөөнөөс эгүүлэн 2 нийт 89 албан хаагчийн томилгоо хийгдсэн бол бүтцийн өөрчлөлтөөр төрийн үйлчилгээний 2, төрийн албанаас түр чөлөөлж, нөөцөд бүртгэсэн 3, бусад төрийн байгууллагад шилжин ажилласан 3, сахилгын шийтгэлээр халагдсан 2, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 13, нас барсан 2 нийт 25 албан хаагчийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 21.2.2, 21.2.3-т заасны дагуу 2 албан хаагчийн эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулах, 20 албан хаагчийн дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 35 албан хаагчийн дэс түшмэлийн зэрэг дэвийг ахиулан олгуулах саналыг салбар зөвлөлийн 09 дүгээр тогтоолоор дэмжиж, холбогдох дээд газруудад хүсэлт хүргүүлжээ.

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын 2020 оны ажлын үр дүнгийн үнэлгээнд үндэслэн цалингийн шатлалыг ахиулах 89 албан хаагчийн цалинг А/77 дугаар тушаалаар шинэчлэн тогтоож, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу Б/07, Б/41, Б/111 дүгээр тушаалаар нийт 22 албан хаагчид нэмэгдлийг тогтоолоо.

Хагас жилийн байдлаар нийт 273 (*давхардсан тоогоор*) албан хаагчид зохих нэмэгдэл, 51 албан хаагчид нэмэгдэл хөлс, 169 албан хаагчид нийт 147,399,137 төгрөг (*Нэг зуун дөчин долоон сая, гурван зуун ерэн есөн мянга нэг зуун гучин долоон*)-ийн урамшуулал, 28 албан хаагчид нийт 64,326,378 төгрөг (*Жаран дөрвөн сая, гурван зуун хорин зургаан мянга гурван зуун далан найман*)-ийн тусламж олгосон ба 43 албан хаагч төрийн дээд одон медаль, салбарын болон байгууллагын шагналаар шагнагдаж, бусад байгууллагын 9 ажилтныг байгууллагын шагналаар шагнасан.

Тайлант хугацаанд 3 албан хаагчид сануулах, 2 албан хаагчид ажлаас халах сахилгын шийтгэлийг тус тус оногдуулсан байна.

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдрийг тохиолдуулан 5 албан хаагчийн төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргад тус байгууллагын албан хаагчдад 130 өрхийн хэрэгцээний зуслангийн газрыг олгож, дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/89 дүгээр албан бичгээр хүргүүлэв.

Улсын Онцгой комиссын даргын тушаалаар Нийслэлийн орон сууцны корпорацийн төрийн албан хаагч нарт олгож буй “Түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууц”-ны хөтөлбөрт 4 албан хаагчийг хамруулж, орон сууцжууллаа.

Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталж, байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан.

Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 71 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулжээ.

Байгууллагын даргын 2021 оны Б/139 дугаар тушаалаар орон нутаг дахь газарт салбар хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар захиргааны ахлах 6 мэргэжилтнийг томилж, хариуцан ажиллах чиг үүргийн талаар зөвлөмж, чиглэлийг хүргүүлээд байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжийн дарга, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын түр эзгүй байх хугацаанд албан тушаалын чиг үүргийг хэрэгжилт, гүйцэтгэлийг орлон ажиллах хуваарийг байгууллагын даргын А/76 дугаар тушаалаар батлав.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд байгаа нийт 310 орон тооны 218 буюу 70.3 хувь нь төрийн захиргааны албан тушаал байгаагийн “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд томилогдсон 21 албан тушаал (*төрийн захиргааны албан тушаалын 9.6 хувийг эзэлж байгаа*)-ын томилгооны зөрчлийг арилгах ажлын хүрээнд сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Эхний хагас жилийн дүнгээр 2020 онд зарлагдсан боловч сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 6 орон тооны сонгон шалгаруулалтыг 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, 6 иргэнийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлж, 04 дүгээр сарын 08-ны өдөр 6 сарын туршилтын хугацаагаар томилсон.

Мөн төрийн захиргааны удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 16, нийт 24 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шалгалтын комиссыг салбар зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан.

Эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 14 дүгээр зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1, “Алтан гадас одон”-оор 4, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 4, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/43 дугаар тушаалаар Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан

хүндэт тэмдгээр 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг-ээр 4, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1, нийт 15 албан хаагч шагнагдсан бол байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулахад санал санаачилга гарган, 2020 онд бусдыгаа манлайлан ажилласан “Байгууллагын хөдөлмөрийн аварга” 3, “Нэгжийн тэргүүний албан хаагч” 12, “Байгууллагын жуух бичиг”-ээр 13 нийт 28 албан хаагч шагнагджээ.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан төрийн дээд одон, медаль болон салбарын шагналд нэр дэвшүүлэхээр олон жил үр бүтээлтэй ажилласан 2 албан хаагчийг төрийн дээд одон “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”-ээр 7, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 19, бусад салбарын шагналд 2 нийт 30 албан хаагчийн нэрийг дэвшүүлж, холбогдох материалыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/729 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

2.1.3. Сургалт:

Гадаадын иргэн, харьяатын газрын сургалтын 2021 оны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталж, хэрэгжилтийг ханган, эхний хагас жилийн байдлаар танхимын болон цахим сургалтын хугацаа, хамрах хүрээг Коронавируст халдвар /КОВИД/-ын цар тахалтай тэмцэх цаг үеийн нөхцөл байдал, хөл хорионы түвшинтэй уялдуулан зохион байгуулж, 5 удаагийн мэргэшүүлэх багц сургалтад 11 албан хаагч, бусад чиглэлийн 14 удаагийн сургалт, семинарт 230 албан хаагч буюу давхардсан тоогоор төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн нийт 241 албан хаагч хамрагдлаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан уг хуулийг дагалдаж гарах журмуудыг албан хаагчид болон хамтран ажиллах байгууллагын зарим албан хаагчдад танилцуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах нэгдсэн удирдамжийг байгууллагын даргын 05 дугаар сарын 25-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газрын газарт шинээр томилогдсон албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин тодорхойлох, байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, онцлог, чиг үүргийг таниулах чиглүүлэх 10 хоногийн сургалтыг “Сургалтын модуль батлах тухай” 2019 оны А/430 дугаар тушаалаар баталсан сургалтын агуулгын хүрээнд зохион байгуулж, шинээр томилогдсон 14 албан хаагчийг оролцуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” цахим сургалтад 42 албан хаагч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа 2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад 20 албан хаагч, мөн тус академиас зохион байгуулсан “Гадаад харилцаа, дипломат ёс, дэг жаягийн тухай ойлголт” сэдэвт сургалтад холбогдох албан хаагчид тус тус амжилттай хамрагдлаа.

Албан хаагчдын баримт бичиг боловсруулах албан хэрэг хөтлөх чадамжийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүйн мэдлэг олгох” 4 удаагийн сургалт, мөн Архивын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлт, удирдлагын баримт бичиг боловсруулах,

түүний хүчин төгөлдөр байдлыг хангах” сэдэвт сургалтад тус тус албан хаагчдыг оролцууллаа.

Түүнчлэн “Дархан-Энх Оршихуй” гадаад хэлний сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан 30 хоногийн англи хэлний анхан болон дунд шатны цахим хичээлд 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдрийн хооронд нийт 113 албан хаагч хамрагдсан.

Байгууллагын мэдээллийн цагт 05 дугаар сарын 28-ны өдөр “Харилцааны ёс зүй”, 21-ний өдөр “Төрийн албаны шинэчлэл, ёс зүйн хандлага” сэдвээр зохион байгуулагдсан сургалтад давхардсан тоогоор 82 албан хаагчийг танхимаар, орон нутаг дахь албан хаагчдыг цахим хэлбэрээр хамруулан ажиллалаа.

2.1.4. Олон нийт, мэдээ, мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой 53 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 267 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевизээр 47, сонинд 12, сайтад 208)-ээр сурталчилсан.

“Засаг цаг” хөтөлбөрт Монгол Улсын холбогдох хууль тогтоомж зөрчиж албадан гаргагдсан иргэдийн тоон мэдээлэл болон хяналт шалгалт, албадан гаргахтай холбоотой дүрс бичлэг, ярилцлагыг хүргүүлж, нэвтрүүлэг 2021 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс, УИХ-ын Тамгын газраас бэлтгэдэг “УИХ-ын цаг” нэвтрүүлэгт Виз зөвшөөрлийн газрын дарга, Олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн оролцож, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон цахим визийн талаар өгсөн мэдээлэл 03 дугаар сарын 10-ны өдрөөс тус тус цацагдаж, олон нийтэд хүрсэн.

Гадаадын иргэний хяналт шалгалттай холбоотой асуудлаар байгууллагын дарга Н.Ууганбаяр 3 дугаар сарын 19-ний өдөр сэтгүүлчдэд мэдээлэл өгч, ТВ9, Ийгл, UBS, ETV телевиз, ikon.mn, news.mn, zindaa.mn, zarig.mn, 24 tsag.mn зэрэг 9 хэвлэл мэдээллийн байгууллага оролцон, байгууллагын цахим хуудас, zarig.mn, odod.mn, erennews.mn, 24tsag.mn, zindaa.mn сайтууд хэвлэлийн хурлыг шууд дамжууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд байгууллагын дарга Н.Ууганбаяр 05 дугаар сарын 05-ны өдөр Bloomberg телевизийн “Ярилцах цаг”, 05 дугаар сарын 17-ны өдөр ТВ8 телевизийн “Толь” мэдээллийн хөтөлбөр, 05 дугаар сарын 19-ний өдөр UBS телевизийн “Нүүр тулсан ярилцлага”, 05 дугаар сарын 21-ний өдөр МҮОНТ-ийн “Цагийн хүрд” хөтөлбөр, 06 дугаар сарын 04-ний өдөр ТВ9 телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөрт 06 дугаар сарын 08-ны өдөр англи хэлээр мэдээ, мэдээллээ бэлтгэн хүргэдэг C Channel Mongolia телевизийн “Онцлох ярилцлага” нэвтрүүлэгт тус тус оролцож, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Мөн дээрх сэдвийн хүрээнд бэлтгэсэн ярилцлагыг “Монголын үнэн” сонины 05 дугаар сарын 10-ны өдрийн дугаарт нийтлүүлж, gogo.mn, eagle.mn, zindaa.mn, 24tsag.mn, newspress.mn, zogii.mn зэрэг 10 сайтад байршуулсан.

Цахим төлбөрийн Гэрэгэ киоск машиныг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг TV8, UBS телевиз, zindaa.mn сайтуудыг оролцуулж олон нийтэд хүргэсэн ба байгууллагын дарга Н.Ууганбаярын “Гэрэгэ киоск” систем ашиглан Гадаадын иргэн, харьяатын байгууллагын 66 төрлийн үйлчилгээг цахимаар авч, төлбөрөө төлөх боломжтой боллоо” гарчигтай

ярилцлага өдөр тутмын “Өдрийн сонин”-ы 05 дугаар сарын 19-ний өдрийн дугаарт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан байгууллагын дарга Н.Ууганбаярын “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлага 04 сарын 01-ний өдөр тус тус нийтлэгдэж, ярилцлагын мэдээллийг 24tsag.mn, ontslokh.mn, zindaa.mn, itoim.mn сайтуудад байршууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулах уулзалт, зөвлөгөөнийг гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран зохион байгуулж, 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан Бүгд Найрамдах Солонгос Улсын ЭСЯ-ны уулзалт, зөвлөгөөнийг UBS, TV8 телевиз, zindaa.mn, montsame.mn, mnews.mn сайтаар, 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын ЭСЯ-ны уулзалт, зөвлөгөөнийг ontslokh.mn, zindaa.mn, mnb.mn сайтаар олон нийтэд мэдээллээ. Мөн байгууллагын даргын хэлсэн онцлох үгийг байгууллагын цахим хуудаст богино видео хэлбэрээр оруулж, арга хэмжээний үеэр зураг, бичлэг хийж архивласан.

2.2: Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдлын чиглэлээр:

2.2.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө бүхий нийт 53 мэдээлэл (зураг, зурагт хуудас, видео)-ийг байгууллагын цахим хуудаст байршуулсан ба цахим хуудас 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 15,240 дагагчтай, хандалт дунджаар 30.341 байна.

Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу байгууллагын даргын 2020 оны А/262 дугаар тушаалаар Дэд даргаар ахлуулсан “Гамшгаас хамгаалах шуурхай штаб” байгуулсан бөгөөд 2021 оны “Гамшгаас хамгаалах шуурхай штабын бүрэлдэхүүн, бүлэг байгуулах тухай” А/53, А/92 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб”-ыг тус тус шинэчлэн тодотголоо.

Мөн Монгол улсын Шадар сайдын 2018 оны “Загвар батлах тухай” 120 дугаар тушаалын дагуу байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, байгууллагын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/93 дугаар тушаалаар батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос баталсан 9 тогтоол, шийдвэрийг мөрдлөг болгон, холбогдох үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед нийт албан хаагчдын тодорхой хувийг ажлын байранд, бусад албан хаагчдыг цахимаар ажиллуулах зохион байгуулалтыг тухай бүр хийж, тушаал шийдвэрээр баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Байгууллагын даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг, түүний хавсралтаар “Гадаадын иргэн, харьяатын газрын Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед ажиллах үйл ажиллагааны горим”-ыг, 2021 оны А/53 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах

шуурхай штаб, бүлэг, түүний ажил үүргийн хуваарь, түргэн цугларах схем”, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед ажиллах ерөнхий зааварчилгаа”-г, түүний хавсралтаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб, бүлэг байгуулах тухай” тус тус баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газрын Гамшгаас хамгаалах шуурхай штабын даргын баталсан 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02-03/03 дугаар удирдамж, төлөвлөгөөний дагуу 03 дугаар сарын 23-ны өдөр байгууллагын төв байранд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед томилгоот бүлгүүдийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодотгож, бэлэн байдлыг хангах, албан хаагчдын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор коронавируст цар тахлын халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариуцлагатай жижүүр, эмч болон халдвар хамгааллын хувцас хэрэглэлтэй ажиллах бүлэг, хэв журам сахиулах бүлгийн ажиллах дадлага сургуулилалтыг зохион байгуулав.

Улсын онцгой комиссын 4 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2 дугаар аяныг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 01/1934 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед ажиллах арга хэмжээний зохицуулалтын тухай” А/13, А/24, А/38, А/63 дугаар тушаал, “Бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах албан хаагчдын жагсаалтыг батлах тухай” А/36 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлсэн.

2021 оны 03 дугаар сарын 20-ний өдөр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд КОВИД-19 вирусийн эсрэг “Синофарм” үйлдвэрийн вакцины 1 дүгээр тунд 82 албан хаагч, 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 2 дугаар тунд 56 албан хаагч төвийн зохион байгуулалтын нэгжээс тус тус хамрагдлаа.

2.3. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.3.1. Хууль, эрх зүй:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Засгийн газрын тогтоолоор батлагдах 4 тогтоолын төсөл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдах 2 тушаалын төсөл, нийт 6 эрх зүйн актын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. Үүнд:

Нэг. Засгийн газрын тогтоолоор:

1. “Монгол Улсын виз олгох журам”;
2. “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”;
3. “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” тогтоолын төслийг тус тус боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/328 дугаар албан бичгээр,
4. “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын төслийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/301 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хоёр. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар:

1. "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журам"-ын төслийг 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/580 дугаар;
2. "Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"-ын төслийг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/452 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдуулан тус байгууллагыг хариуцагчаар татсан 3 захиргааны хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх үйл ажиллагаа хийгдэж, 1 захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлээд байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн Choi Yong Bin-ийн нэхэмжлэлтэй, Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүх хурлаар Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/220 дугаар тушаалын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн Aodeng-ийн нэхэмжлэлтэй, Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хурлаар байгууллагын гомдлыг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүйд тооцсон.

МОНГОЛ Улсын иргэн Э.Энхзоригийн нэхэмжлэлтэй, Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдох захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

"Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам"-ыг 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/82 дугаар, "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ыг А/78 дугаар тушаалаар тус тус баталж, мөрдүүллээ.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгах зорилт, арга хэмжээний саналыг 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/267, байгууллагын хэмжээнд шинээр батлах захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/260 албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэв.

2.3.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Япон улсын ЭСЯ-ны консул Ёшиканэ Казүноритэй 03 дугаар сарын 01-ний өдөр, Бүгд Найрамдах Солонгос Улсын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ким Тэ Ван болон албаны бусад хүмүүстэй 03 дугаар сарын 04-ний өдөр, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Меена, хоёрдугаар нарийн бичгийн дарга Манан нартай 03 дугаар сарын 16-ны өдөр тус тус танилцах уулзалт хийлээ.

Тайлант хугацаанд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ЭСЯ-ны атташе, Бүгд Найрамдах Казакстан Улсын ЭСЯ-ны Консулын хэлтсийн дарга, Жайка Олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, орлогч

дарга, Тайваний хоёрдугаар нарийн бичгийн дарга, Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ-ны Бүс нутгийн аюулгүй байдлын атташе, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Монгол дахь хөрөнгө оруулагчдын Зун Хуа нийгэмлэгийн төлөөлөгч, ӨМӨЗО-ын Монгол дахь худалдааны ерөнхий танхимын нарийн бичгийн дарга, ӨМӨЗО-ны Олон улсын худалдааг дэмжих холбоо ба Эрээн хотын олон улсын худалдааг дэмжих холбооны Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын төлөөлөгч нарын хүмүүсийг тус тус хүлээн авч, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар албан хэргийн уулзалт зохион байгуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан байгууллагын дарга Н.Ууганбаяр Зун Хуа нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Баяннуурын бизнесийн холбооны Уул уурхайн худалдан авалт хариуцсан компанийн дэд тэргүүн нартай 05 дугаар сарын 19-ний өдөр, Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга болон албаны бусад хүмүүстэй 05 дугаар сарын 25-ны өдөр, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдтай 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус уулзалт зохион байгуулж, хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцлоо.

2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ЭСЯ болон Монгол дахь хөрөнгө оруулагчдын Зун Хуа нийгэмлэгтэй хамтран Монгол Улсад оршин суугаа Хятад Улсын хөрөнгө оруулагчид, иргэдэд “Шинэчлэн батлагдсан гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга уулзалт, зөвлөгөөн” сэдэвт 2 цагийн арга хэмжээг зохион байгуулав.

Түүнчлэн хил орчмын аялал жуулчлалтай холбогдуулан Монгол-Хятадын соёл, бизнесийг дэмжих холбооны төлөөлөгч Мо Ри Гэн, Эрээн хотын олон улсын худалдааг дэмжих холбооны Монгол Улс дахь төлөөлөгч Амгалан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Баясгалан нартай 05 дугаар сарын 19-ний өдөр нэг өдрийн аялал жуулчлал, визийн төлбөрийн асуудлаар уулзалт зохион байгуулсан.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа 2050”, “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээг цахимжуулах, гадаадын иргэдэд үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор eViza.mn цахим сайтын мэдээллийг англи хэл рүү, Гэрэгэ Системс киоск төхөөрөмжийн үйлдлийн системийн мэдээллийг англи, орос, солонгос, хятад хэл рүү, “Хилийн аюулгүй байдлын нэгдсэн систем”-ийн танилцуулгыг англиас монгол хэлнээ тус тус хөрвүүлжээ.

Бусад орны ижил чиг үүргийн байгууллагуудын шинэ мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр бэлтгэн долоо хоног тутам Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газарт цахим хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Тайлант хугацаанд 25 албан хаагчид 72 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр ашиглалтад олгож, 84 албан хаагчид 1055 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, хуулбарлан өгсөн.

2020 оны баримт бичгийг архивд хүлээн авах хуваарийн дагуу нийт албан хаагчаас файл (5 ширхэг DVD)-аар болон 792 хадгаламжийн нэгжийг бүртгэлийн дагуу хүлээн авч, сан хөмрөгийн бүрдүүлэлт хийж ажиллав.

Байгууллагад ирүүлсэн нийт 1153 албан бичиг (*хариутай 389*)-ээс 285 шийдвэрлэгдэж, 104 албан бичиг шийдвэрлэх шатандаа байгаа бөгөөд 976 албан бичгийг гадагш илгээсэн. Хариутай албан бичгээс нийт 4 албан бичиг хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна.

Байгууллагын даргын баталсан 285 тушаал (*А тушаал 125, Б тушаал 160*)-ыг бүртгэж, цахим хэлбэрт шилжүүлэн ажиллалаа.

2.4.2. Өргөдөл, гомдлын чиглэлээр:

2021 оны эхний хагас жилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчдаас нийт 160 өргөдөл (*төвийн зохион байгуулалтын нэгжид 111, боомт, орон нутгийн нэгжид 49*) ирүүлснийг хүлээн авч, 155 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 5 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. 30 хүртэл хоногоор сунгаж шийдвэрлэсэн 2 өргөдөл байгаа бол хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1: Программ хангамж:

“Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох цахим систем хөгжүүлэх” 01/07-05 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем /RNSF/-ийг 06 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулж, мөн сарын 10-ны өдрийн байдлаар нийт 100,444 гадаадын иргэнд регистрийн дугаар олгосон.

Гадаадын иргэн, харьяатын газрын “Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох” /RNSF/ программ болон Хил хамгаалах ерөнхий газрын “Гадаадын иргэний био мэдээллийн бүртгэлийн систем”-ийн хооронд мэдээлэл харилцан солилцох ажил явагдаж байна.

“Гадаад иргэнийг бүртгэх бүртгэлийн аппликейшн хөгжүүлэх” 01/07-06 дугаартай гэрээний дагуу Гадаадын иргэнийг 48 цагийн дотор гар утаснаас бүртгэх бүртгэлийн аппликэйшнийг хөгжүүлж, 06 дугаар сарын 04-ний өдөр эхний хувилбарыг нэвтрүүлэв.

Түүнчлэн Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газартай “Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг ашиглах” ХУР/20-17 дугаартай гэрээг 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, “Танилтад нэвтрэлтийн нэгдсэн систем /ДАН/-ийг ашиглах” 01/11-02 дугаартай гэрээг мөн оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тус тус шинэчлэн байгуулж, төрийн байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох боломжийг бүрдүүллээ. “ХУР” системээр 48 төрлийн сервисээр мэдээлэл авч, 21 төрлийн сервисээр бусад төрийн байгууллагад мэдээлэл өгч байна.

Eimmigration.mn цахим хуудсаар дамжуулан нийт 2 төрлийн тодорхойлолтыг цахимаар олгож байна. Үүнд:

- оршин суух зөвшөөрлийн талаарх тодорхойлолт;
- цагаач, гэр бүлийн болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тодорхойлолт.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цахим төлбөрийн Гэрэгэ киоскийг үйлчилгээндээ нэвтрүүллээ. Гэрэгэ Киоскоор дамжуулан байгууллагын үйлчилгээний төлбөр, тэмдэгтийн хураамж, торгууль зэрэг 66 төрлийн төлбөр төлөх боломжтой болсон.

“Визийн мэдээллийн нэгдсэн сан” төсөл 2021 оны 05 дугаар сараас эхлэн тус байгууллагад хэрэгжиж, сангийн хөгжүүлэгч шалгаруулах тендерт шалгарсан Интерактив ХХК 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс системийн хөгжүүлэлтийг

эхлэн 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар цахим визийн eVisa.mn сайтаар дамжуулан визийн хүсэлтийг хүлээн авах эхний хувилбарыг ажиллагаанд орууллаа.

Мөн байгууллагын цахим хуудсыг шинэчлэн, НҮБ-ын 5 хэл дээр хөгжүүлэлтийг хийж, 6 дугаар сард багтаан үйл ажиллагаанд хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж байна.

ISM системийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд визийн хяналтын модулийг шинээр гаргаж, 03 сарын 20-ны өдөр ажиллагаанд оруулан, хилийн боомтуудад ажиллах албан хаагчдын батлагдсан хуваарийн дагуу хэрэглэгчийн эрхийн шилжилт хөдөлгөөнийг тухайн сар тутамд хийж ажиллав.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2021 оны эхний хагас жилийн байдлаар 3,917.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 2,680.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу өр, авлагагүй, хэмнэлттэйгээр, зохих журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн саналыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/622 дугаар, урсгал төсвийн хязгаарын саналыг 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/740 дүгээр албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Үндэсний аудитын газраас Төсвийн төвлөрүүлэн захирагч болон Төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэлт авч ажиллалаа.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоол, 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2021 оны эхний хагас жилийн байдлаар тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлого нийт 406.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.6.3. Хангалт, худалдан авалт:

Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/212 дугаар тушаалаар батлагдаж, байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 төрлийн 621,9 сая төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээний тендерийг холбогдох хууль, журмын дагуу зарлаж, ГИХГ/202112001 дугаартай шатахуун, ГИХГ/202112002 дугаартай нормын хувцас, ГИХГ/202112003 дугаартай багаж техник хэрэгсэл, ГИХГ/202112004 дугаартай мэдээллийн технологийн үйлчилгээний тендерийн нээлтийг тус тус зохион байгуулсан.

Тендерт шалгарсан Петростар ХХК, Бат зүү ХХК, Билэг дизайн ХХК, Монтех дистрибьюшн ХХК, Лидер Вишн групп ХХК, Голден хоул ХХК-тай бараа, үйлчилгээ нийлүүлэх гэрээг тус тус байгууллаа.

2020 оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 01/1755, 01/1769 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлж, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг www.tender.gov.mn, www.shilendans.gov.mn вэб хуудаст байршуулсан.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Тайлант хугацаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудыг түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугч, цагаач, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар, хяналт шалгалт, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлсэн талаарх нийт 30 удаагийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг 26 удаагийн албан бичгээр хүргүүлэн, мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг нийт 12 удаа хийн, тайланг гаргаж, холбогдох байгууллага болон албан тушаалтанд тухай бүр танилцуулж ажилласан.

Байгууллагын 2020 оны болон 2021 оны эхний хагас жилийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тус тус 2 удаа хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч, Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 01/137, 01/862 албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээ 2020 онд 100 хувь, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 98.56 хувиар үнэлэгдсэнийг 2019 оны үнэлгээтэй харьцуулахад байгууллагын ил тод байдлын үнэлгээ өсөлт бууралтгүй, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 0.66 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Байгууллагын даргын 2021 оны А/52 дугаар тушаалаар байгуулсан Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, аюулгүй байдал алдагдах эрсдэлийг үнэлэх зорилго бүхий Ажлын хэсгийн “Эрсдэлийн үнэлгээний тайлан”-г төвийн зохион байгуулалтын нэгжийн дарга нарт 04 дүгээр сарын 09/05 дугаар дотоод албан бичгээр танилцуулж, зөвлөмж хүргүүллээ.

2.7.2. Аудит:

Байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар 2020 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг 2021 оны 01 дүгээр сард 01/82 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, дотоод аудитын чиглэлээр 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлав.

Нийцлийн аудитын чиглэлээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2 удаагийн хяналт шалгалтыг хийж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн shilendans.gov.mn сайтад байршуулсан мэдээлэлд байгууллагын даргын 2021 оны 01-09/01, 01-09/14 дүгээр удирдамжийн дагуу 2020 оны IV улирал, 2021 оны I дүгээр улирлын байдлаар дотоод аудит хийлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан виз, зөвшөөрлийн чиглэлээр хүчин төгөлдөр үйлчилж буй Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон байгууллагын даргын баталсан тушаал шийдвэрт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хяналт-шинжилгээ хийсэн.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Энэ оны 01 дүгээр сард олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа гадаадын иргэн болон тусгай үүргийн нислэгээр ирсэн гадаадын иргэдэд хяналт тавих ажлын хүрээнд 24 орны 1,495 гадаадын иргэн Монгол Улсын хилээр орж, 54 орны 2,285 гадаадын иргэн хилээр гарсан буюу нийт 56 орны 3,780 гадаадын иргэний хил нэвтрэлтэд хяналт тавихад ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журам”-ын төсөлд өгөх саналыг 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/677 дугаар албан бичгээр Улсын онцгой комисст, Монгол Улсын хил хааснаас хойш тус улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн талаарх судалгааг 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/768 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлсэн.

Мөн Цагаандэл-Уул хилийн боомтын төлөвлөлтийн асуудлаар 05 дугаар сарын 13-ны өдрийн цахим хурлын шийдвэрийн дагуу тус боомтыг түр горимоор нээн ажиллуулахад байгууллагад шаардагдах зардлын тооцоог 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/699 дүгээр албан бичгээр Гаалийн ерөнхий газрын Боомтын хөгжлийн хэлтэст хүргүүлэв.

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслөөс хэрэгжүүлж буй хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай зорчих нөхцөл, хилийн хяналтын байгууллагуудын ажиллагсдын ажиллаж амьдрах орчныг сайжруулах чиглэлээр Баянхошуу, Булган, Ханги, Хавирга, Сүмбэр, Цагааннуур хилийн боомтын өргөтгөл шинэчлэлийн ажилтай холбогдуулан боловсруулсан урьдчилсан төлөвлөлттэй танилцаж, холбогдох саналыг 02 дугаар сарын 23-ны өдрийн 03/273 дугаар дотоод албан бичгээр хүргүүлсэн.

Боомт, орон нутаг дахь нэгжүүд 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дотооддоо нийт 10 удаагийн сургалтыг зохион байгуулж, нэгжийн албан хаагчид байгууллагаас зохион байгуулсан нийт 10 удаагийн сургалтад хамрагдаж, бусад байгууллагаас зохион байгуулсан 26 удаагийн сургалтад оролцжээ.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР